



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 14

Мандалговь

Г

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх
албан тушаалын сонгон шалгаруулалтын
комисс томилох тухай

7

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3.2, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга: -Ц.Эрдэнэсүрэн (Салбар зөвлөлийн дарга, Аймгийн Засаг
даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: - Л.Баярсайхан (Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн)
- А.Ганбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн
сангийн хэлтсийн дарга)
- Н.Мөнгөн (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэдээлэл
технологийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: С.Хулан (Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн
бичгийн дарга)

Хоёр. “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасан сонгон шалгаруулах комиссын чиг үүргийг хэрэгжүүлэн, шалгалтын бэлтгэлийг ханган, зохион байгуулж холбогдох мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг комисс /Ц.Эрдэнэсүрэн/-т даалгасугай.



132021038